

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/15/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Атарцэцэг
Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2024/06/НА-СТА-ТШЗ



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН
ДАРГА Г.ГАНБАТ ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.05 № 24

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хорихоос өөр төрлийн ял - Зорчих эрх хязгаарлах ялаар шийтгэгдсэн этгээдэд цахим хяналт тавих нөхцөлийг бүрдүүлсэн ба эргэлт уулзалтыг цахимаар зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр уулзалтын өрөөг тохижуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2,685.5 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй 16,694.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 9,903.0 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 хөтөлбөр, 4 зорилт, 49 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 46 арга хэмжээг бүрэн, 2 арга хэмжээг 70.0 хувь, 1 арга хэмжээг 80.0 хувь буюу нийт дүнгээр 97.6 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

- 07020198


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	51,918.58	46,353.18
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,011,713.32	955,614.87
Нийт хөрөнгийн дүн	1,063,631.90	1,001,968.05
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,063,504.65	1,001,968.05
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,063,504.65	1,001,968.05
Үйл ажиллагааны орлогын дүн	789,636.68	902,944.89
Үйл ажиллагааны зардлын дүн	626,065.85	964,481.48
Үйл ажиллагааны үр дүн	163,570.83	(61,536.59)
Үйл ажиллагааны бус үр дүн	833.33	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	162,737.50	(61,536.59)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	1,063,504.65	1,001,968.05
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	900,767.15	1,063,504.65
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
Тайлант оны үр дүн	162,737.50	(61,536.59)
Эцсийн үлдэгдэл	1,063,504.65	1,001,968.05
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	634,756.80	880,896.90
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	571,835.90	878,211.90
Үйл ажиллагааны ЦМГ	62,920.90	2,685.00
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(62,920.90)	(2,685.00)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	634,756.80	870,023.83
Урсгал зардал	634,756.80	870,023.83
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	634,756.80	870,023.83
Улсын төсвөөс санхүүжих	633,906.80	868,871.33
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	850.00	1,152.50

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 305.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Хуультай холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 305.0 мянган төгрөгийн гүйлгээг системд нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар 1 зөрчил² илэрч зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 11984 м.кв талбай газрыг 2077 м.кв талбайгаар илүү, 3335 м.кв талбай газрыг 2935 м.кв талбайгаар дутуу нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх"; 13 дугаар зүйлийн 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүр хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй газрыг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэх.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөр 305.0 мянган төгрөгийг татварын нэвтрэлтийн нэгдсэн системд дутуу шивсэн байна.	1	305.0	1	305.0	-	-	1	305.0	-	-	-	-
Дүн		1	305.0	1	305.0	-	-	1	305.0	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 11984 м.кв талбай газрыг 2077 м.кв талбайгаар илүү, 3335 м.кв талбай газрыг 2935 м.кв талбайгаар дутуу нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-
Дүн		1	-	-	-	1	-	-	-	-	-	-

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэри	Алдаа, зөрчлийн товч утга		Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	4	3	4	5	6	7	8	9	10
Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	Түлш халаалтын зардалд 29,929.2 мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч худалдан авах ажиллагаа зарлагүйгээр шууд худалдан авалт хийсэн.	29,929.2	1	29,929.2	-	-	1	29,929.2	-	-
	дүн		1	29,929.2	-	-	1	29,929.2	-	-